



“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК

2026 оны 03 дугаар сарын 11

Багануур дүүрэг

Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан

- Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн цахилгаан хангамжийн 110/35/10кВ-ын 2х16мВА чадалтай үндсэн дэд станцын барилга угсралтын ажлыг эхлүүлэх ажлын хүрээнд: Цахилгаан хангамжийн 110/35/10кВ-ын 2х16мВА чадалтай үндсэн дэд станц барих ажлын 1,048.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын эрхийг Нийслэлийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А/430 дугаар захирамжаар Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт шилжүүлсэн. Гүйцэтгэгчээр “Эм Ай Эс Эс” ХХК нь шалгарч 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай №ОН2512001438 гэрээ байгуулсан.

- Паркийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажил: Худалдан авах ажиллагааны газраас тендерийг 2025.10.17-ны өдөр зарлаж гүйцэтгэгчээр Аж үйлдвэрийн паркийн технологи дамжуулах төв шалгарч гэрээ байгуулах бэлтгэл ажил хийгдэж байна.

- Паркийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ шинэчлэн боловсруулах: Худалдан авах ажиллагааны газраас тендерийг 2025.10.17-ны өдөр зарласан боловч гүйцэтгэгч шаардлага хангаагүй тул тендерийг 2025.12.17-25-ний хооронд дахин зарлаад байна.

- Нийслэлийн засаг даргын 2026 оны 01 дүгээр сарын 28-ний өдрийн А/100 захирамжаар Паркийн үйлдвэрийн албан конторын барилгын засварын зураг төслийн 46.8 сая.төг санхүүжилт шийдвэрлэгдсэн. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил хийгдэж байна.

- Нийслэлийн засаг даргын 2026 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн А/268 захирамжаар Паркийн хүнд үйлдвэрлэлийн бүсийн ХЕТ-ний зураг төслийн 298.6 сая.төг санхүүжилт шийдвэрлэгдсэн. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил хийгдэж байна.

Мэдээлэл өгөх ажилтан:
Үйлдвэрлэл, технологийн
хэлтсийн дарга Б.Мөнгөнхуяг.
Утас: 88656964